



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/156

Хэрлэн сум

**Дэлхийн эмч нарын баярыг
тохиолдуулан эмч нарт урамшуулал олгоход
дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан иргэдэд тусламж үйлчилгээг чанартай үзүүлж, гүйцэтгэлийн санхүүжилтийг амжилттай хэрэгжүүлж буй эмч нарт 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийн урамшуулал олгоход дэмжлэг үзүүлсүгэй.


2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 28-ны
... дугаар захирамжийн хавсралт

УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Урамшуулал олгох эмчийн овог, нэр	Эрхэлж байгаа албан тушаал	Урамшууллын хэмжээ	ХАОАТ-ын суутгал	Гарт олгох
1	Цэвээндолгор Цэвээн-Идэр	Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Дүрс оношилгооны их эмч	100,000	10,000	90,000
2	Ганболд Ариунзул	Норовлин сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч	100,000	10,000	90,000
3	Хүрэлбаатар Доржханд	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга	100,000	10,000	90,000
4	Болд Мөнбиш	Бэрх тосгоны Эрүүл мэндийн төвийн эрхлэгч	100,000	10,000	90,000
Нийт дүн			400,000	40,000	360,000